

**“АЛСЫН ХАРАА -2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН
2025 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ХЭРЭГЖИЛТ**

2025 оны 04 дүгээр сарын 04

Улаанбаатар хот

№	Үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин		Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу гүйцэтгэлийн хувь /хүрээгүй бол шалтгаан, нөхцөл тайлбар/
				Он	Түвшин		
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 2.7.Монгол хүний удмын санг хамгаалж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлж, монгол хүний хөгжлийг дэмжинэ.							
2.7.3.	Гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалж, бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно.	0.0	Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийн хөгжүүлэлт	2024	Шинэчлэн хөгжүүлэх программ хангамжийн тоо-1	Үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна.	Монгол Улсад 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар 1831 гадаадын иргэн, үүнээс хамгийн их буюу БНХАУ-ын 1252 иргэн Монгол Улсад цагаачлан оршин суухаар бүртгэлтэй байгаа нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэгт заасан хэмжээнээс хэтрээгүй байна. Монгол Улсад 2009-2012 онд оруулж болох цагаач гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай УИХ-ын 2009 оны 44 дүгээр тогтоолоос хойш тогтоолыг шинэчлэн батлаагүй бөгөөд Гадаадын иргэн, харьяатын газраас “Монгол Улсад 2021-2024 онд цагаачлуулж болох гадаадын иргэдийн тоо, бүтэц, байршлын тухай” УИХ-ын тогтоолын төсөл, танилцуулгыг 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 01/1730 дугаар, 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 01/2075 дугаар албан бичгээр тус тус Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн. “Гадаадын иргэний виз, бүртгэл мэдээллийн нэгдсэн сан (isf.mn)” системийг нэвтрүүлэх арга хэмжээг 2022 онд Хууль зүй, дотоод хэргийн сайдын улсын төсвийн хөрөнгө оруулалтын “Тоног төхөөрөмж” багцаас 470.0 сая төгрөгийн санхүүжилтээр ашиглалтад оруулж, үйл ажиллагаанд нэвтрүүллээ. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам, И-Монгол академитай хамтран танилт нэвтрэлтийн ДАН системд гадаадын иргэний бүртгэл (F-Register) ашиглан нэвтрэх үйлчилгээг уг системтэй 2023 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс холбон үйлчилгээ үзүүлж эхэлсэн.

1	2	3	4	5	6	7	8
							“Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” системийг ашиглалтад оруулснаас хойш 845 удаагийн засвар, шинэчлэлийг хийж, хөгжүүлэлтийг сайжруулан визийн зөвшөөрөл, виз, оршин суух зөвшөөрөл, оршин суух зөвшөөрлийн хугацаа сунгалт, оршин суух зөвшөөрлийн хасалт, оршин суух зөвшөөрлийн хэлбэр өөрчлөлт, паспортын мэдээлэл өөрчлөлт, оршин суух зөвшөөрлийн хаягийн өөрчлөлт, оршин суух үнэмлэх дахин авах, гадаадын иргэний бүртгэлтэй холбоотой нийт 71,197 хүсэлтийг хүлээн авсан ба үүнээс 20,289 хүсэлтийг 1 дүгээр улиралд хүлээн авч тус тус хянан шийдвэрлэлээ. Системийн хөгжүүлэлтэд 2025 оны 1 дүгээр улиралд байгууллагаас төсөв зарцуулаагүй болно.
Үнэлгээ 100 хувь							

--oo0oo--